

Монгол Улсын Шадар сайдын
2025 оны 04 дүгээр сарын 02 ны
өдрийн 37 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (цаашид ХАБҮЛЛ гэнэ)-ийн үндсэн үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй, хууль ёсны дагуу хэрэгжүүлэх, нийтлэг зарчим, бүрэн эрх, олон улсын болон бусад байгууллагатай харилцах хэм хэмжээг тодорхойлж, зохицуулна.

1.2. ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагааг нь Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Цөмийн энергийн тухай хууль, "АЛСЫН ХАРАА-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон бусад хууль тогтоомжийн хүрээнд явагдана.

1.3. Хуулиар тусгайлан зохицуулаагүй харилцааг энэхүү дүрэм болон холбогдон гарах эрх зүйн актуудаар зохицуулна.

1.4. ХАБҮЛЛ нь хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бие даасан, хараат бус хэмжилт шинжилгээ, тандалт судалгаа хийх үүрэг бүхий төсвөөс санхүүждэг төрийн өмчит хуулийн этгээд мөн.

1.5. ХАБҮЛЛ-ийн оршин байгаа газар: Монгол Улс, Улаанбаатар хот-17042, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-75

1.6. ХАБҮЛЛ нь өөрийн нэрийн бэлгэ тэмдэг (лого), тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны харилцах данстай байна.

1.7. ХАБҮЛЛ-ийн оноосон нэр нь:

- Монголоор "Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори", товчилсон нэр "ХАБҮЛЛ" байна.

- Англиар "National reference laboratory for Food safety", summary name "NRLFS" байна.

1.8. Алсын хараа: Дотоодын болон импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх чанар, аюулгүйн үзүүлэлтийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар, орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан тодорхойлж, улсдаа тэргүүлэх лавлагаа лаборатори болно.

1.9. Эрхэм зорилго: Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх

хими, биологи, цацрагийн бохирдлыг тодорхойлж, бүх төрлийн хүнс, гоо сайхан, ахуйн химийн бүтээгдэхүүн, таримал ургамлын үр, хөрс ус, агаарт чанар, аюулгүйн үзүүлэлтүүдийн шинжилгээ хийхээс гадна орон нутгийн хяналтын лабораториуд болон итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх стандартын сургалт зохион байгуулах, ур чадварын сорилтыг зохион байгуулах, шинжилгээний үр дүнгийн мэдээллийн санг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийхэд оршино.

1.10.ХАБҮЛЛ-ийн үндсэн зорилт: Орчин үеийн арга аргачлал, техник технологи ашиглан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн бүрэн шинжилгээ хийх олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн Үндэсний Лавлагаа Лаборатори болно.

Хоёр. Үйл ажиллагааны зарчим

2.1.ХАБҮЛЛ нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

2.1.1.шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд тулгуурласан, хараат бус хөндлөнгийн байр сууринаас хийсэн үнэн бодит хэмжилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчийг хангана.

2.1.2.дотоод, гадаадын байгууллага, хувь хүнтэй холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ хэлэлцээр хийж, хамтран ажиллана.

2.1.3.үндсэн болон бүтцийн нэгжийн бие даасан байдлыг хангах, хариуцлага хүлээх боломж, чадварыг нэмэгдүүлнэ.

2.1.4.мэргэжилд суурилсан мэдлэгийг эрхэмлэн ажилтнаа сонгон шалгаруулж авах бөгөөд эерэг хандлагыг төлөвшүүлж, ажлын эрх ашгийн үүднээс зохих шаардлага тавина.

Гурав. ХАБҮЛЛ-ийн үндсэн чиг үүрэг

3.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шинжилгээ, тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад тухай бүрд хүргүүлэх;

3.2.Орон нутгийн сорилтын лабораториудын хүнсний шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлэх;

3.3.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтыг шинэчилж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

3.4.Лабораторийн шинжилгээний шинэ арга аргачлал боловсруулах, аргын баталгаажуулалт хийх, итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит хүнсний лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах;

3.5.Орон нутгийн хяналтын лабораториудыг үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн өмчит лабораториудтай хамтран ажиллах, бусад лабораториудад зөвлөгөө өгөх,

мэргэжил дээшлүүлж, мэргэшүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах;

3.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээний маргаан таслах баталгаажуулах шинжилгээг хийх;

3.7.Өргөх байгууламжид техникийн бүрэн ээлжит, хэсэгчилсэн магадлал, баталгаажилтыг хийх.

Дөрөв. Удирдлагын тогтолцоо, эрх үүрэг:

4.1.ХАБҮЛЛ-ийн Захирлыг Монгол Улсын Шадар сайд томилж, чөлөөлнө.

4.2.Захирал нь дараах эрхтэй.

4.2.1.ХАБҮЛЛ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг чанар болон техникийн менежер, лабораторийн эрхлэгч, алба, төвийн дарга нараар дамжуулан удирдах;

4.2.2.Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргана.

4.2.3.ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагааг дотоод болон гадаад төлөөлөх;

4.2.4.ХАБҮЛЛ-ийн төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

4.2.5.ХАБҮЛЛ-ийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг холбогдох эрх зүйн орчинд нийцүүлэн эрх бүхий этгээдээр батлуулах;

4.2.6.ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлого, албан тушаалын тодорхойлолтыг эрх зүйн орчинд нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

4.2.7.Маргаантай асуудлаар лабораторийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах, төлөөлөх;

4.2.8.Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

4.3.Захирал дараах үүрэгтэй.

4.3.1.Лабораторийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан, нягтлан бодох бүртгэлийн тайлан, тэнцэл, мэдээ, мэдээлэл гаргах зэргийг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

4.3.2.Ажиллагсдын аюулгүй, таатай орчинд ажиллах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах, тогтвортой ажиллах бүтээлч хамт олныг бүрдүүлэх;

4.3.3.Батлагдсан орон тоо, цалингийн сангийн хүрээнд ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг ажлын үр дүнтэй уялдуулан олгох;

4.3.4.Хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.

4.4.Захирал дэргэдээ шийдвэр гаргахад зөвлөх, удирдлагын шуурхай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдлагын зөвлөл, орон тооны бус Эрдмийн зөвлөл, Мэргэжлийн зөвлөлтэй байна.

4.5.Удирдлагын зөвлөл нь Захирал, нэгжийн удирдлагууд, чанар болон техникийн менежерүүдээс бүрдэнэ.

4.6.Удирдлагын зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй.

4.6.1.Байгууллагын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам бусад эрх зүйн акт боловсруулах асуудлыг хэлэлцэх, санал өгөх, биелэлтийг хангуулах;

4.6.2.Санхүүгийн үйл ажиллагааг хэлэлцэх, санал өгөх;

4.6.3.Бүтцийн нэгжүүдийн тайлан, төлөвлөгөөг хэлэлцэх;

4.6.4.Шагналд нэр дэвшүүлэх, хариуцлага тооцох асуудлыг хэлэлцэх, санал өгөх;

4.6.5.Үндсэн нэгжийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог өөрчлөх, шинээр бий болгох асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;

4.6.6.Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тайланг хэлэлцэж, санал гаргах;

4.7.Эрдмийн зөвлөл нь ХАБҮЛЛ-ийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж, тогтоол гаргах бөгөөд гишүүдийг хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, байгаль орчин зэрэг чиглэлээр мэргэшсэн, эрдмийн зэрэг, цолтой эрдэм шинжилгээний ажилтан, судлаач, мэргэжилтнүүдээс бүрдүүлнэ.

4.8.Мэргэжлийн зөвлөл нь ХАБҮЛЛ-ийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, лаборатори хоорондын уялдаа холбоог хангахтай холбоотой зөвлөмж гаргах бөгөөд хүнсний лабораториудын удирдлагуудаас бүрдэнэ.

Тав. Бүтэц, зохион байгуулалт

5.1.ХАБҮЛЛ-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог Монгол Улсын Шадар сайд батална.

5.2.Санхүүгийн тайлан болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнана.

5.3.ХАБҮЛЛ нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах захиргаа удирдлагын нэгж, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжүүд, сорилт шинжилгээний төрөлжсөн лавлагаа лабораториудтай байна.

5.3.1.Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах Захиргаа удирдлагын нэгж нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, салбарын хууль, тогтоомжийн биелэлтийг удирдан зохион байгуулах, төлөвлөгөө,

тайланг нэгтгэн хариуцах, төрийн байгууллагын дүрэм, журам, стандартад нийцүүлэн лабораторийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулах инженер, техникийн нөхцөл боломжоор хангах, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангахад төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавьж, мэдээллийн ил тод байдлыг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, авлига, хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлж, төрийн албаны стандарт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ;

5.3.2. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжүүд нь хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэг, арга хэмжээтэй уялдуулан тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хүнсний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтыг боловсруулан батлуулах болон лабораторийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх ба хүнсний лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах, төрийн болон хувийн хэвшлийн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ;

5.3.3. Төрөлжсөн лабораториуд нь итгэмжлэгдсэн байх бөгөөд микробиологи, хими, хор судлал, цацраг, хорио цээрийн чиглэлээр бүх төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, гоо сайхан болон ахуйн химийн бүтээгдэхүүн, хөрс ус, агаар, таримал ургамал, үрийн материалд үндэсний болон олон улсын стандарт арга, аргачлал ашиглан шинжлэх ухааны нотолгоонд тулгуурласан үнэн бодит үр дүн гаргах, лабораторийн шинжилгээний шинэ арга, аргачлал боловсруулах, аргын баталгаажуулалт хийх, хүнсний аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт, эрүүл ахуйн болон ариун цэврийн арга хэмжээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн төсөлд санал өгөх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжлэх, шаардлагатай бол онцгой байдлын болон гамшгийн үед авсан дээжид шинжилгээ хийхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

5.3.4. ХАБҮЛЛ-ийн зохион байгуулалтын нэгжийг нэгжийн дарга нар удирдана.

Зургаа. Хариуцлага

6.1. ХАБҮЛЛ-ийн дүрэм, байгууллагын дотоод журам, гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг зөрчиж, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, зөрчил дутагдал гаргасан нь тогтоогдсон албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Бусад

7.1. Энэхүү дүрэм нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.